

МОНГОЛ УЛСЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СТРАТЕГИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Д.Начин*

Монгол улсын Ерөнхийлөгчийн захирамжаар Монгол улсын хөгжлийн цогц бодлогын баримт бичиг боловсрогдож байна. Мянганы хөгжлийн зорилтуудыг хангахад чиглэгдсэн үндэсний хөгжлийн цогц бодлого нь хүний хөгжил, засаглал, эдийн засаг, байгаль орчин гэсэн 4 үндсэн хэсэгтэй бөгөөд эдийн засгийн бодлого нь хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг хангах, үйлдвэрийн, хөрөнгө оруулалтын, төсвийн бодлогоор тодорхойлогдох юм.

Эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангах үндсэн нөхцөл нь хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, улсын хөрөнгө оруулалтыг ДНБ-ий тодорхой хувьд байлгах зэрэг замаар хангагдах бөгөөд үүний үр дүнд хувийн хөрөнгө оруулалт өсч, энэ хэмжээгээр ажлын байр бий болохоос гадна дотоодын хөрөнгийн боломж нэмэгдэх юм. Эдийн засгийн өсөлтийн стратеги нь жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх (2005-2010), аж үйлдвэрийг хөгжүүлэх (2010-2015), оюуны багтаамжтай үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх (2015-2021) гэсэн 3 үе шаттай.

Татварын бодлогоор экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжиж, инфляцийг оновчтой удирдан зохицуулж, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах юм. Банк санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгож зээлийн хүүг бууруулан, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдүүлнэ. Макро эдийн засгийг хөшүүргүүдийг хэрэглэн Монгол улсын өрсөлдөх чадварыг сайжруулж, гадаад худалдааны таатай орчин бий болгоно гэж тодорхойлжээ.

Татварын бодлогын тэргүүлэх зорилт, хэрэгжүүлэх стратеги нь экспортын баримжаатай дараах үйлдвэрлэл, үйлчилгээ, импортыг орлох зарим үйлдвэрлэлийг татварын оновчтой бодлогоор дэмжихэд чиглэгдэнэ. Үүнд:

* МУИС, ОУХС-ийн ахлах багш, докторант, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн хэлтсийн дарга

- Эрдэс түүхий эд, ноос ноолуур, мах, сүү, арьс шир боловсруулах салбарын үйлдвэрлэлд өндөр технологи нэвтрүүлэх,
 - Электроник, оюуны багтаамжтай бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
 - Импортыг орлох зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
 - Экспортын баримжаатай “Брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэл,
 - Экспортын баримжаатай үйлчилгээ, эхний ээлжинд аялал жуулчлалын салбарыг оновчтой дэмжинэ.
 - Гаалийн тарифын бодлогыг үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцаа, бүтцийг бий болгох, өрсөлдөх чадвартай дотоодын үйлдвэрлэлийн өсөлт, тэргүүний техник, технологийн импорт, боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт,
 - Түүнчлэн татварын бодлогоор дотоодын хөрөнгө оруулалтыг болон өндөр хөгжсөн орнуудын үндэстэн дамнасан корпорацуудын хөрөнгө оруулалтыг зохистой дэмжихээр заасан байгаа.
- Өрсөлдөх чадварыг сайжруулах тэргүүлэх зорилт, хэрэгжүүлэх стратеги нь үйлдвэрлэл, үйлчилгээнд өндөр технологийг нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхдээ дараах арга замаар хэрэгжүүлэх юм. Үүнд:
- Гадаадын, ялангуяа өндөр хөгжсөн орнуудын үндэстэн дамнасан корпорациудын хөрөнгө оруулалтыг татах эдийн засаг, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх.
 - Эдийн засгийн чөлөөт бүс болон бусад хууль эрх зүйн тусгай зохицуулалттай бүсүүдийг байгуулж ажиллуулан өндөр технологи нутагшуулахыг дэмжих.
 - Судалгаа шинжилгээний ажил, зохиогчийн эрхийн ашиглалтад хөрөнгө зарцуулж байгаа үйлдвэр, аж ахуйн газруудыг урамшуулж өндөр технологи нутагшуулахыг дэмжих.
 - Бүс нутгууд, хөдөөд өндөр технологи нутагшуулах таатай орчин бүрдүүлэх.
 - Үйлдвэрлэл, технологийн парк, хөгжлийн парк, бизнесийн инкубатор, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн парк, үйлчилгээний худалдааны экспортын парк, холимог үйлдвэрлэлийн парк зэрэг өндөр технологи нутагшуулах төвүүдийг байгуулж ажиллуулах.
- Гадаад худалдааны бодлогын тэргүүлэх зорилт, хэрэгжүүлэх стратеги нь гадаад худалдааны нэн таатай орчин бүрдүүлэх, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг

зохистой өсгөх, импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулахад чиглэгдэж дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- Дэлхийн болон Ази тив, бүс нутгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж гадаад худалдааны таатай орчин бүрдүүлж, Дэлхийн худалдааны байгууллагын гишүүний хувьд худалдааны тааламжтай нөхцөл, экспортын хөнгөлөлт, тусгай нөхцлийг үр дүнтэй, бүрэн дүүрэн ашиглах,
- Далайд гарцгүй, хөгжиж буй орны хувьд барааг транзит орны нутаг дэвсгэрээр саадгүй дамжин өнгөрүүлэх, хөнгөлөлттэй нөхцөл эдлэх чиглэлээр хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх,
- Дэлхийн болон бүс нутгийн худалдааны интеграцид идэвхтэй оролцож, байр сууриа бэхжүүлж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны байгууллагуудын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж манай улсын экспортын бүтээгдэхүүний эзлэх байр суурийг бэхжүүлэх,
- Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг өсгөх,
- Эдийн засгийн өсөлтөд тэргүүлэх ач холбогдолтой эрдэс түүхий эдийн экспортыг үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатанд дотоодын хуримтлал бий болгох зорилгоор өсгөж, дараагийн үе шатанд аажмаар бууруулж энэ чиглэлийн эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх,
- Боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлттэй уялдуулан экспортыг өсгөж, мах, арьс шир, ноос, ноолуур зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, эрүүл ахуйн болон дэлхийн стандартын шаардлага хангасан, экологийн цэвэр эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх,
- Оюуны багтаамжтай бага оврын бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг өсгөх,
- Мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох зорилготой уялдуулан импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг оновчтой болгох,
- Өндөр технологи бүхий боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, уул уурхайн болон дэд бүтцийн салбарын орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн импортыг түлхүү дэмжих,

- Оюуны багтаамжтай бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийн импортыг дэмжих - эдгээр болно.

Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын тэргүүлэх зорилт, хэрэгжүүлэх стратеги нь өндөр технологид тулгуурлан стратегийн орд газруудыг ашиглан эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулж мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох санхүүгийн чадавхи, хуримтлалыг бүрдүүлэх гэсэн нэгдүгээр үе шат (2007-2015), уул уурхай, ашигт малтмалын салбарт тэргүүний техник, технологийн эрчим - хоёрдугаар үе шат (2016-2021)-аас бүрдэх бөгөөд дараах арга замаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх,
- Эдийн засгийн өсөлтөд тэргүүлэх ач холбогдолтой эрдэс түүхий эдийн ашиглалтыг үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дотоодын хуримтлалыг бий болгох зорилгоор өсгөх (нэгдүгээр үе шат),
- Ашигт малтмалын ашиглалтын орлогыг “Монголын хөгжлийн сан”-д төвлөрүүлж, Монголын ард түмэнд ашигтайгаар зохистой ашиглах,
- Оюу толгойн, Цагаан суваргын, Таван Толгойн, Асгатын, Цавын, Төмөртэйн, Чойр-Нялгын болон бусад томоохон стратегийн орд газруудыг ашиглаж эхлэх (нэгдүгээр үе шат),
- Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх,
- Катодын зэсийн үйлдвэрлэлийг эрс өсгөх (2015 он гэхэд 400 мянган тонн цэвэр зэс үйлдвэрлэх - нэгдүгээр үе шат),
- Коксжих нүүрсийг боловсруулж эхлэх,
- Газрын тосны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх,
- Эрдсийн түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний гаралтыг нэмэгдүүлэх зэрэг болно.

Төсвийн хөрөнгө оруулалтаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулж, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоход чиглэгдсэн дараах төслүүдийг дэмжинэ. Үүнд:

- Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Бүсийн хөгжлийг хурдасгах томоохон “зүтгүүр” төслүүд,

- Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн паркууд байгуулахад шаардлагатай нийтлэг дэд бүтцийг барьж байгуулах,
- Мэдээлэл, холбооны технологийг нэвтрүүлэх, техник мэргэжлийн боловсрол олгох тогтолцоог сайжруулах зэрэг эдгээр болно.

Төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжигдэх эдгээр төслүүд, тухайлбал “зүтгүүр” төслүүдийг дагалдах буюу тойрсон ажил, үйлчилгээний төслүүд нь гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих юм.

ГШХО-ыг чөлөөтэй оруулах, үйл ажиллагааг нь дэмжих нэг хэрэг, харин улс орны хөгжилд шийдвэрлэх нөлөө бүхий ГШХО-ыг стратегийн хөрөнгө оруулагчид, тэргүүлэх салбараар нарийвчлан боловсруулан хэрэгжүүлэх, ялангуяа жижиг эдийн засаг, зах зээлтэй манай улсын хувьд дараах зүйлд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- тодорхой, нарийн чиглэлтэй байх (үйлдвэрлэл, үйлчилгээний ямар салбар, үйл ажиллагаа, аль улс оронд чиглэж, ямар компани, хэн гэдэг менежерт хандаж хөрөнгө оруулалтыг татах сурталчилгаа, үйл ажиллагаа явуулах),
- олон улсын өрсөлдөх чадвар нь батлагдсан үйлдвэрлэл, түүний нийлүүлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх бололцоо манайд байгаа эсэхийг судлах,
- ирээдүйд хэрэгцээ байгаа бол хөгжил нь тааруухан байгаа үйлдвэрлэл ч бас давуу талтай байж болно гэж үзэх,
- гол бүтээгдэхүүнээр өрсөлдөж байгаа бусад ямар улс орнууд байгаа, өвөрмөц бүтээгдэхүүний хэрэгцээ, ямар бүтээгдэхүүний ангилал дэлхийн худалдаанд хамгийн их хэрэгцээтэй байгаа, тэдгээрийн динамикийн талаар судлах,
- үйлчилгээний болон худалдааны статистикт хараахан тусгагдаагүй боловч бий болох экспортын боломжуудыг ГШХО-тай уялдуулж судлах,
- экспортод чиглэсэн фирмүүдийг татахад өвөрмөц үйлдвэрлэлийн компаниудын тоо, тэдгээрийн нийлүүлэлт хийх өндөр чадавхи нь чухал үзүүлэлт юм. Үүнд байгалийн баялгийн (эрдэс түүхий эдийн, эрчим хүчний нөөц) болон хүний нөөцийн (боловсролын янз бүрийн түвшний чадвар, их, дээд сургуулиуд, судалгаа-шинжилгээний ажил) үзүүлэлтүүд мөн орно.
- экспортын чиг баримжаатай ГШХО-ыг татахдаа тодорхой чиглэлтэй, нарийн стратеги боловсруулан хэрэгжүүлэх (хөрөнгө оруулалтыг татах сурталчилгаа нь хэдий чинээ тодорхой нарийн чиглэгдсэн, өгч байгаа мэдээлэл нь хир зэрэг

хангалттай байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулах шийдвэр гаргах магадлал тэр хэмжээгээр өндөр байна),

- олноор үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг бус харин ажиллах хүчнээс дунд болон дээд түвшний мэргэшил шаардсан, цөөн тоогоор үйлдвэрлэх өвөрмөц бүтээгдэхүүнийг дэмжих, тухайлбал, хувцасны загвар, арьс шир, үнэт эдлэлийн өвөрмөц загвар зохион бүтээх, цөөн тоогоор үйлдвэрлэх,
- өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор өндөр технологийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулахаар чармайж буй хувийн хэвшлийн, ЭШ-ний байгууллага, хувь хүмүүсийн хамтын ажиллагааны үр өгөөжтэй механизмыг бий болгох, өндөр технологид дунд хэмжээний хөрөнгө оруулж, нэмүү өртөг их шингэсэн, ур чадвар их шаардах бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох зорилго тавих.
- улс орны хөгжлийн стратегийн үндэс нь хүний хөгжлийн асуудал болохыг байнга анхаарах,
- ЖДҮ-үүдэд санхүүгийн онлайн үйлчилгээ үзүүлж тэдгээрийн мэдлэгт суурилсан нийгэм байгуулахад оруулах боломж, хувь нэмрийг нэмэгдүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих бэлтгэлийг хангах.
- гадаадын хөрөнгө оруулагчид, гүйцэтгэх захирлуудад тав тухтай, аюулгүй орчинд сонирхолтой амьдрах бололцоо олгох чиглэлээр ажиллах, тэд нартай зөвлөлдөх, гадаадын хөрөнгө оруулагчдын санал, сэтгэгдэл, тэдгээрээс хөрөнгө оруулалтын “амьд баталгаа” авах нь хөрөнгө оруулалт хаана хэрэгтэй байгааг эрж хайхад тустай.
- дунд, ахлах түвшний дипломатууд, холбогдох төрийн албан хаагчдыг хөрөнгө оруулалтыг урамшуулах, хөрөнгө оруулалтыг (тодорхой бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, хөрөнгө оруулагчдад хандаж татах) нарийвчлан чиглүүлж татах
- практик үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргах үйл ажиллагааных нь талаар сургалтанд хамруулж байх,
- Монгол улс нь өөрөө хөрш хоёр том орны зах зээлд үйлчилдэг зах зээл болохыг ойлгуулах зэрэг эдгээр болно.

ГШХО стратегийг үндэсний хөгжлийн цогц бодлоготой нягт уялдуулах, хөгжлийг тодорхойлогч салбарууд, зүтгүүр төслүүдийг дэмжих, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглүүлэх, ингэхдээ маш тодорхой, чиглэсэн зорилго бүхий цогц арга хэжээнүүдийг авах шаардлагатай болох нь харагдаж байна.